

CENTRAL SYDNEY INTENSIVE ENGLISH HIGH SCHOOL

57-77 Mitchell Road ALEXANDRIA NSW 2015

Tel: 9595 9200

Email: CentralSydneyIEHS.school@det.nsw.edu.au

Principal: Jennifer Pilon

Эрхэм хүндэт эцэг эх, асран хамгаалагч нарт,



MONGOLIAN

COVID-19 ШИНЭ МЭДЭЭ болон Зр УЛИРЛЫН СУРГУУЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Энэ захиа таньд болон танай гэр бүлд саадгүй хүрнэ гэж найдаж байна.

2020 оны 8-р сарын 17-ны Даваа гарагт NSW Боловсролын Яамнаас сургуулиудад зориулсан COVID-19 үеэр үйл ажиллагаа болон хичээлээ хэрхэн явуулах талаархи зааварчилгаандаа нэмэлт өөрчлөлт хийсэнг доорх мэдээллээс авна уу.

Сургуулийн Ирц

Өвдсөн болон сургуульдаа ирэх боломжгүйг нотолсон эмнэлгийн гэрчилгээтэйгээс бусад бүх тохиолдолд бүх сурагчид хичээлдээ ирэх ёстой.

Хэрэв Сурагч Өвдсөн Бол

NSW Эрүүл Мэндийн Яамны зөвлөгөөний дагуу таньд хүүхэддээ хамгийн анхан шатны зөөлөн ханиад томууны шинж илэрхэд ч сургуульд нь явуулахгүй байхыг анхааруулж байна.

NSW Эрүүл Мэндийн Яам нь COVID-19ны шинж тэмдэгээр дараах шинж тэмдэгүүдийг зөвлөж байна:

- халуурах (≥ 37.5),
- ханиах
- хоолой өвдөх, хүндүүрлэх
- амьсгаа давчидах (амьсгалахад хэцүү байх)
- үнэрлэх болон амтлах мэдрэмжээ алдах.

Мөн COVID-19 бусад шинж тэмдэгт дараах шинж тэмдэгүүд орно:

- бие сульдах
- нус гойжих
- булчин хөндүүрлэх, өвдөх
- үе мөч хөндүүрлэх, өвдөх
- толгой өвдөх
- гүйлгэх
- дотор муухайрах/бөөлжих
- хоолны дуршилаа алдах.

NSW Эрүүл Мэндийн Яам нь ханиад томууны шинж болон үнэрлэх болон амтлах мэдрэмжээ алдах эсвэл шалтгаангүйгээр халуурвал COVID-19ны шинжилгээ өгөх ёстойг зөвлөж байна.

Хэрэв таний хүүхэд сургууль дээр өвдвөл бид таньтай холбогдон сурагчийг ирж авхыг шаардах болно. Эмч COVID-19ны шинжилгээг зохион байгуулж өгөх учир та хүүхдээ заавал эмчид үзүүлэхийн чухлыг ойлгоно уу. Таны хүүхдийн COVID-19ны шинжилгээ нь сөрөг гарсан болон бие нь сайн байвал сургуульдаа буцан ирж хичээлээ үргэлжлүүлэх боломжтой. Та сургуульд хүүхдийнхээ COVID-19ны шинжилгээ нь сөрөг гарсан хариуг нь хүүхдээ сургуульд буцан ирхээс өмнө нь өгөх ёстойг анхаарна уу.

Сургууль дээрх аюулгүй байдлыг хангах

Манай сургууль нь бүх багш ажилчид болон сурагчдынхаа эрүүл мэнд аюулгүй байдлыг хамгаалах үүднээс хоорондоо зай барих болон халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх бусад хувийн мөрдөх шаардлагатай журмуудыг үргэлжлүүлэн дагаж мөрдөж байна. Дараахь хувийн ариун цэврийн шардлагыг манай сургууль баримтлаж байна. Үүнд:

- гараа тогтмол угаах

- сургууль дээр байрлуулсан гар ариутгагч ашиглан гараа тогтмол ариутгах
- хичээлд ашиглах зүйлсээ арчих, цэвэрлэх
- ундаа, хоол хүнс хуваалцахгүй байх
- хичээлд ашиглах зүйлсээ хуваалцахгүй байх
- найтаах эсвэл ханиахдаа тохойгоороо эсвэл нэг удаагийн амны цаасаар ам хамраа дарах-хэрэглэсэн цаасаа тэр дор нь хаях
- гоожуураас ус шууд уулгүйгээр усны сав авчиран түүнээсээ уух.

Аюулгүй байдлыг хангах үүднээс 3р Улиралд дагаж мөрдөх нэмэлт үйл ажиллагаанууд

Сургуулиуд дээр COVID-19-ийн тархах эрсдэлийг бууруулах үүднээс 3-р Улиралын турш дагаж мөрдөх нэмэлт шаардлагууд:

- Бие биендээ ойртох нөхцлийг хязгаарлах үүднээс боломжтой бол оюутнууд сургуулийнхаа үйл ажиллагаанд хамрагдахдаа зөвхөн өөрийн харъя анги бүлэгтэйгээ (жишээлбэл анги, бүлэг, шат гм) ажиллах болно.
- Сургууль хоорондын үйл ажиллагаа нь тухайн ойр орчиндоо зохиогдоно. Энэ нь сургууль хоорондын зохион байгуулдаг сургалтын хөтөлбөрт байдаг сургуулийн биеийн тамир болон спортын бүх үйл ажиллагаа, урлагийн болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамаарна.
- Зөвхөн сургалтын хөтөлбөрийн хүрээн дэхь зайлшгүй шаардлагатай хөтөлбөрүүд л үргэлжлэн явагдах болно.
- Эцэг эх, асран хамгаалагч болон бусад чухал бус зочдыг сургуулийн талбайд нэвтэрхийг хориглох болно.
- Бүх төрлийн хамтлагаар дуулах (найрал дуу) болон/эсвэл бусад дуулах үйл ажиллагаанууд, мөн хамтлаг бүлгээр хөгжмийн зэмсэг ашиглахыг хориглоно.

Гадуур явах

NSW Нийтийн Тээврийн зүгээс оюутнууд болон бусад зорчигчид галт тэрэг, автобус болон усан онгоцоор явахдаа амны маск зүүхийг зөвлөж байна.

Further advice

NSW Боловсролын Яамны гэр бүлүүдэд зориулсан нэмэлт COVID-19той холбоотой зөвлөгөөг эндээс <https://education.nsw.gov.au/covid19> авна уу.

Шинэчилсэн COVID-19 зөвлөгөөг өдөр бүр SBS [sbs.com.au/coronavirus](https://www.sbs.com.au/coronavirus) дээрээс авах боломжтой. Мэдээллүүд нь 50 гаруй хэл дээр бэлтгэгдсэн.

Би, боловсролын салбарт урьд өмнө тохиолдож байгаагүй энэ цаг үед эцэг эх, асран хамгаалагчдаас хүлээн авсан дэмжлэгт, хамтын ажиллагаанд талархаж байна..

Энэ цаг үе нь шинээр ирж буй сурагчид, тэдний гэр бүл болон асран хамгаалагчдын хувьд маш хүнд байгаа гэдгийг ойлгож байгаа бөгөөд бүх сурагчид, гэр бүлүүд болон багш ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал мөн сургалтаа цаашид үргэлжлүүлэхийг Төв Сидней Эрчимжүүлсэн Англи Хэлний Ахлах Сургуул нь үндсэн санаа тавих ёстой асуудлаа болгож ажиллаж байгаа гэдэгт бидэнд итгээрэй.

Хэрэв таньд COVID-19 холбоотой асуулт болон нэмэлт мэдээлэл хэрэгтэй бол сургуультай 9595 9200 утсаар холбогдоорой.

Хүндэтгэсэн,

Jennifer Pilon

Захирал

17 August 2020